

ОНГОН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
03 ДУГААР САРЫН МЭДЭЭ

2023.03.30

Хавирга

**Нэг. Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр:**

**Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тамгын газар, төрийн удирдлагын ажлын чиглэлээр**

Иргэдийн төлөөлөгчдийн хурлын I улирлын хурлыг зохион байгуулсан.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг даргын тамгын газарт I улиралд иргэд, албан хаагчдаас ирүүлсэн өргөдлийг нэгтгэн аймгийн ЗДТГ-т явуулсан. Шийдвэрлэлт 89.1 хувьтай.

Төсвийн байгууллагын 100 албан хаагчийг “Алсын хараа 2050” сургалтанд хамруулж, Батламж авахуулсан.

**Хоёр. Эдийн засаг төсөв санхүүгийн бодлогын хүрээнд:**

Сумын санхүүгийн 2022 оны нэгдсэн тайланг төсөв, төрийн сангийн хэлтэст хугацаанд нь хүргэсэн.

Нийгмийн даатгалын байцаагчтай тухай бүр тооцоо нийлж, өр авлагагүй ажилласан.

Сар бүрийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн мэдээ, төрийн сангийн мэдээ, өглөг авлагын мэдээг хугацаанд нь үнэн зөв гаргаж цахим сүлжээгээр дамжуулан төрийн сангийн хэлтэст өгсөн.

Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн мэдээллийн судалгааг гаргаж статистикийн газарт явуулсан.

**Гурав. Хууль эрх зүйн бодлогын хүрээнд:**

Иргэд, төрийн албан хаагчдад Тамгын газрын мэргэжилтнүүдээс 04 дүгээр сард хууль, эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа хүргэх хуваарь гарган, мөрдөж эхэлсэн.

**Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:**

Аймгийн нэгдсэн эмнэлгээс элэгний В, С вирусын шинжилгээ авах, вирус тоолох ажлыг Эрүүл мэндийн төвд ирж зохион байгуулсан.

“Энэ жилдээ – Эрүүл жиндээ” аяны нээлтийн арга хэмжээг төрийн албан хаагч, иргэдийг оролцуулан эрүүл мэндийн сургалт, зөвөлгөө зохион байгуулж

Соёлын төвөөс “Ээжтэйгээ хамт” гэрэл зургийн уралдаан, “Баярын жавхаа” тэмцээн, сумын уран сайханчдын “Эрхэмсэг” тоглолт, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан сэдэвчилсэн “Монгол цэрэг” номын үзэсгэлэн зэрэг соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулсан.

Музейн нээлттэй өдрүүдийн хүрээнд

- 1.“Түүх хүүрнэхүй” явган аялал 7-р ангийн сурагчдад /28 хүүхэд хамрагдсан/
- 2.“Урилгатай зочин” тойм яриа 11-р ангийн сурагчдад /34 хүүхэд хамрагдсан/
- 3.“Монгол гэрийн онцлог” ярилцлага цэцэрлэгийн 4 бүлэгт /55 хүүхэд хамрагдсан.

Сумын залуучуудын зөвлөлөөс залуу малчин 10 өрхөд төл хүлээн авахад дэмжлэг болгон шаардлагатай зүйлсээр багц бэлдэн, хүлээлгэн өгсөн.

Шинээр ашиглалтанд орсон сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэн БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар хичээлийн 160 ширээ, сандал шинээр авсан. Мөн аймгийн аварга шалгаруулах уралдаан тэмцээнээс 6 алт, 2 мөнгө, 7 хүрэл медаль хүртэж, олимпиадын II шат болон “Оюун ухааны наадам”-аас 1 алт, 3 мөнгө медаль авч улсын олимпиадад 1 багш, 1 сурагч оролцохоор болсон.

**Тав: Хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын хүрээнд:**

Сумын хэмжээнд малын сэг зэм устгах, их цэвэрлэгээний ажлыг засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилон зохион байгуулж 100 адуу, 130 үхэр, 760 хонь, 510 ямаа, нийт 1500 малын сэг зэмийг устгаж, 150.000мкв талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийсэн. Мөн 6 төсөвт байгууллага, 20 ААН, 2 колонкийн гадна орчинд ариутгал хийсэн.

Хогийн нэгдсэн цэгийг ландфилл технологиор цэгцлэхээр “Би би сервис” ХХК, “Ээлтэй зам” ХХК-уудтай гэрээ байгуулсан.

МЭДЭЭ БОЛОВСРУУЛСАН:  
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН

С.АЗБИЛЭГ